



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Хөгжлийн банкны 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/106/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663, цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-260512, цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитын менежер: Б.Саруул Утас: 51-261805, цахим хаяг: saruulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Туяадарь Утас: 51-261456, цахим хаяг: tuyadarii@audit.gov.mn Аудитын менежер: П.Ундармаа Утас: 51-261585, цахим хаяг: undarmaap@audit.gov.mn Аудитын менежер: Б.Өлзий Утас: 11-329874, цахим хаяг: ulziib@audit.gov.mn Аудитын менежер: Б.Золбаяр Утас: 11-315578, цахим хаяг: zolbayarb@audit.gov.mn Ахлах аудитор: Ч.Ариунаа Утас: 11-329874, цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn Аудитор: Б.Буянхишиг Утас: 51-261456, цахим хаяг: buyankhishigb@audit.gov.mn Аудитор: М.Доржханд Утас: 51-261745, цахим хаяг: dorjkhandm@audit.gov.mn Аудитор: Б.Бүрэнхүү Утас: 51-261745, цахим хаяг: zendmened@audit.gov.mn Аудитор: Д.Зэндмэнэ Утас: 11-315578, цахим хаяг: zendmened@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.5.1 Завсрын аудитын талаар.....	25
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа	26
5.1.2 Зөвлөмж	27
5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил	28
5.2.1 Төлбөрийн акт.....	29
5.2.2 Албан шаардлага	30
5.2.3 Зөвлөмж	32
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	35

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
МИК	Монголын ипотекийн корпораци
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НОСК	Нийслэлийн орон сууцны корпораци
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ӨБҮХХ	Өмчлөхөөс бусад үл хөдлөх хөрөнгө
СТОУС	Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарт
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
ЭУГ	Эрсдэлийн удирдлагын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ С.БААТАРСҮРЭН ТАНАА

2026.03.16 № 736
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын тайлан, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 1,546,671.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг, өргөн тархсан байна. Тухайлбал,

- Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 11,091.9 сая төгрөгийг харилцагч байгууллагаар баталгаажуулаагүй;
- Тайлант онд 33 зээлийн үндсэн болон хүү, алдангийн төлбөрийн 2,331,849.3 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 25 зээлийн 1,234,002.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Бараа материал, өмчлөхөөс бусад хөрөнгө, борлуулах зориулалттай нийт 141,156.3 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй;
- ТОСК бондын эргэн төлөгдөх эх үүсвэрийн мөнгөн урсгал, үнийн цэнийн бууралтыг үнэлэн 69.48 хувиар буюу 134,343.6 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулахаар тооцсон ч эрсдлийн санг байгуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.1, 12 дугаар зүйлийн 12.2 дугаар заалт, СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл стандартын 5.1.1, 5.1.7, СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт стандартын 9 дэх заалт, НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр, толилуулга стандарттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК 2020 онд Эрдэнэс Монгол ХХК-тай гэрээ байгуулж, 550,000.0 сая төгрөгийн 5 жилийн хугацаатай баталгаа гаргасан ба 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр дуусгавар болсон байна. Гэвч Эрдэнэс Монгол ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үүргийн гүйцэтгэлийг хангаагүй 849,807.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, талууд 2025 онд тооцоо нийлээгүй, төлөлт хийгдээгүй байна. Засгийн газрын 2025 оны 32 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт "Эрдэнэс бонд"-ын эргэн төлөлтийг хангах зорилгоор "Монгол Улсын Хөгжлийн банк" ХХК-аас гаргасан "Эрдэнэс бонд"-ын баталгаа 550,000.0 сая төгрөгтэй тэнцэх баталгааг чөлөөлж, Монгол Улсын Засгийн газрын баталгаагаар солих, эсхүл эргэн төлөлтийг хангах бусад шаардлагатай арга хэмжээ авахыг Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайдад даалгаж, Монгол банкны Ерөнхийлөгчид зөвлөсүгэй" гэж заасан ч Засгийн газар баталгаа гаргаагүй, үүргийн гүйцэтгэл хангагдаагүй байхад МУХБ баталгааг тэнцлийн гадуурх данснаас шууд хасалт хийсэн байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Хөгжлийн банк нь 2025 оны бизнес төлөвлөгөөнд зээлийн багцыг 50.0 хувиар нэмэгдүүлж, 2,000,000.0 сая төгрөгийн шинэ зээл олгохоор, олон улсын зах зээлээс 800.0 сая ам.долларын эх үүсвэр татахаар төлөвлөж, 500.0 сая ам.долларын эх үүсвэр татсан ч тайлант хугацаанд шинээр зээл олгоогүй, төлөвлөгөөний хэрэгжилт 62.5 хувьтай. Банкны үйл ажиллагааг дунд хугацаанд чиглүүлэх тодорхой стратеги бүрэн тодорхойлогдоогүй, жилийн бизнес төлөвлөгөөний уялдаа хангалтгүй байгаа нь зээлийн үйл ажиллагааг төлөвлөсөн түвшинд хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан, зээл олгох үйл ажиллагаа зогсонги байдалд орсон нь төлөвлөлтийн бодит байдал, удирдлага зохион байгуулалт, шийдвэр гаргах хуваарилалтын уялдаагүй байдал, хяналтын үр нөлөөтэй тогтолцоо алдагдсаныг харуулж байна.

Тайлант онд 33 зээл бүртгэлтэй байгаагаас 25 зээл чанаргүй ангилалд шилжиж зээлийн багцын чанар эрс муудсанаас хүүгийн орлого буурч, 2023 онд 34,420.8 сая төгрөг, 2024 онд 27,344.8 сая төгрөг, 2025 онд 75,180.3 сая төгрөгөөр хүүгийн зардал нь орлогоосоо давж, банкны алдагдал цаашид нэмэгдэх нөхцөл бүрдсэн байна. Энэ нь зээлийн эрсдэлийн удирдлага, зээл олголт болон хяналтын тогтолцоо хангалтгүй байсныг харуулж байгаа бөгөөд банкны санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэл үүссэн байна.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарсан 12 зээлийн хувьд шүүхийн шийдвэрт тусгасан барьцаа хөрөнгийн үнэлгээний дүнг эрсдэлийн сангийн тооцоололд ашигласан байна. Энэхүү шийдвэрт эдгээр барьцаа хөрөнгүүдийн үнэлгээг, зээл олгох үед Банк зээлдэгчтэй барьцаа хөрөнгийн гэрээ хийх хүрээнд үнэлгээ хийж тогтоосон дүнгээр тусгасан учир энэхүү үнэлгээ нь тухайн барьцаа хөрөнгийг борлуулан ирээдүйд орж ирэх төлбөрийн өнөөгийн бодит үнэ цэнийг зөв зохистой тооцсон гэдэг хангалттай нотолгоо болж чадахгүй байна.

Бусад мэдээлэл

Тус банкны санхүүгийн тайланг НББОУС 1-т (Санхүүгийн тайлангийн илэрхийлэл) нийцүүлэн, Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайдын 2015 оны А/35/20 дугаар хамтарсан тушаалаар батлан гаргасан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу аккруэл сууриар бэлтгэсэн байна.

Дээрх зааврын дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр бэлтгэсэн санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу хөрвүүлж, Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн бөгөөд тус тайланг хянаж, баталгаажууллаа.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р-сарын 31
			/төгрөгөөр/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	361,954,096,283.86	1,096,475,453,051.05
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	0.02	0.02
1.1.3	Хөрөнгө оруулалт	356,835,040,832.60	560,302,992,533.60
1.1.4	Зээл (цэвэр дүнгээр)	1,294,322,794,261.81	1,296,200,364,563.75
1.1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	2,559,996,792.35	14,039,904,506.46
1.1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	162,132,318,446.39	210,007,049,505.74
1.1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	642,146,497.46	10,419,802,749.51
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,178,446,393,114.49	3,187,445,566,910.13
	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	22,336,870,345.56	21,617,725,818.03
1.2.2	Борлуулах зориулалттай хөрөнгө	76,508,603,519.63	2,467,000,000.00
1.2.3	Биет бус хөрөнгө	236,381,460.75	257,897,766.05
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	99,081,855,325.94	24,342,623,584.08
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,277,528,248,440.43	3,211,788,190,494.21
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	3,160,662,366.26	7,995,114,402.49
2.1.2	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	453,752,301,460.39	268,269,843,311.16
2.1.3	Бусад эх үүсвэр	1,392,012,467,953.57	2,604,579,654,355.69
2.1.4	Дериватив санхүүгийн өр төлбөр	1,381,977,616.43	29,146,053,522.87
2.1.5	Бусад санхүүгийн өр төлбөр	2,759,270,409.32	7,264,717,358.37
2.1.6	Бусад санхүүгийн бус өр төлбөр	36,649,825,804.86	44,196,143,985.38
2.1.6.1	Хойшлогдсон татварын өр төлбөр	35,217,680,329.19	35,533,580,716.68
2.1.6.2	Бусад санхүүгийн бус өр төлбөр	1,432,145,475.67	8,662,563,268.70
	Өр төлбөрийн нийт дүн	1,889,716,505,610.83	2,961,451,526,935.96
2.2	Эздийн өмч		
2.2.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,216,300,340,598.47	1,216,300,340,598.47
2.2.2	Дахин үнэлгээний нэмэгдэл	26,276,637,711.00	27,224,338,873.50
2.2.3	Хуримтлагдсан ашиг, алдагдал	(854,765,235,479.87)	(993,188,016,563.73)
	Эздийн өмчийн дүн	387,811,742,829.60	250,336,662,908.24
	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	2,277,528,248,440.43	3,211,788,190,494.21

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Мөрийн дугаар	Орлого, зардлын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-рсарын 31
			/төгрөгөөр/
1	Хүүгийн орлого	161,310,700,972.00	165,812,772,526.97
2	Хүүгийн зардал	188,655,483,755.90	240,993,046,785.05
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	(27,344,782,783.90)	(75,180,274,258.08)
4	Эрсдэлийн сангийн зардал	(63,571,465,512.38)	(18,790,699,751.06)
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	36,226,682,728.48	(56,389,574,507.02)
6	Бусад орлого	8,169,608,863.99	(16,481,659,677.44)
6.1	Хүүгийн бус орлого	2,805,129,349.44	(16,989,936,690.16)
6.2	Бусад орлого, олз	5,364,479,514.55	508,277,012.72
7	Бусад зардал	19,765,113,852.74	65,293,318,922.32
7.1	Хүүгийн бус зардал	19,710,796,102.74	65,184,590,885.69
7.2	Бусад зардал, гарз	54,317,750.00	108,728,036.63
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	24,631,177,739.73	(138,164,553,106.78)
9	Орлогын татварын зардал	36,915,481,513.54	258,227,977.08
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	(12,284,303,773.81)	(138,422,781,083.86)

Монгол Улсын Хөгжлийн банкний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	(12,284,303,773.81)	(138,422,781,083.86)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	844,863,938.52	947,701,162.50
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	-	-
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	(11,696,002,517.89)	947,701,162.50
13.5	Бусад		
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)	(23,980,306,291.70)	(137,475,079,921.36)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

					/төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг/алдагдал	Нийт дүн
1	2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,216,300,340,598.47	38,817,504,167.41	(517,485,301,954.32)	737,632,542,811.56
2	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(844,863,938.52)	(324,995,629,751.74)	(325,840,493,690.26)
3	Залруулсан үлдэгдэл	1,216,300,340,598.47	37,972,640,228.89	(842,480,931,706.06)	411,792,049,121.30
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-		(12,284,303,773.81)	(12,284,303,773.81)
5	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(11,696,002,517.89)		(11,696,002,517.89)
6	2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,216,300,340,598.47	26,276,637,711.00	(854,765,235,479.87)	387,811,742,829.60
7	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
8	Залруулсан үлдэгдэл	1,216,300,340,598.47	26,276,637,711.00	(854,765,235,479.87)	387,811,742,829.60
9	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-		(138,422,781,083.86)	(138,422,781,083.86)
10	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		947,701,162.50		947,701,162.50
11	2025 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,216,300,340,598.47	27,224,338,873.50	(993,188,016,563.73)	250,336,662,908.24

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:		
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	24,631,177,739.73	(138,422,781,084.00)
1.2	Орлого, зардлын тохируулга:	(41,791,509,512.75)	(11,707,883,292.00)
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	(77,046,971,873.52)	1,152,018,916.00
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	932,903,803.14	1,133,599,657.00
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	12,360,467,273.81	(88,737,804,888.00)
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(161,310,700,972.00)	(165,812,772,527.00)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	188,655,483,755.90	240,993,046,785.00
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	-	(435,971,235.00)
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	(5,382,691,500.08)	-
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	(17,035,861,185.74)	(46,849,062,577.00)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(1,705,147,929.87)	19,266,517,111.00
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	134,608,217,759.89	(199,841,496,567.00)
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	25,037,101,994.27	174,622,996,440.00
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	17,004,457,425.97	(15,559,033,551.00)
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(193,771,995.18)	-
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	(68,861,411,339.19)	8,318,882,135.00
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	(115,670,011,193.85)	(48,615,194,869.00)
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	(7,255,295,907.79)	14,958,266,724.00
1.4	Бусад тохируулга:	(68,011,949,457.14)	(72,216,374,306.00)
1.4.1	Авсан хүү (+)	109,702,934,119.41	139,769,472,185.00
1.4.2	Төлсөн хүү (-)	(168,469,107,908.63)	(208,763,296,700.00)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(9,245,775,667.92)	(3,222,549,791.00)
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(102,208,142,415.89)	(269,196,101,259.00)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(381,222,329.00)	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(337,530,329.00)	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(43,692,000.00)	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(381,222,329.00)	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	952,639,967,554.06	(2,149,105,462,237.00)
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	817,615,836,000.00	(2,149,105,462,237.00)
3.1.5	Бусад	135,024,131,554.06	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(630,688,682,700.81)	3,152,773,074,752.00
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	(143,480,901,904.55)	3,158,513,358,990.00
3.2.6	Бусад	(487,207,780,796.26)	(5,740,284,238.00)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	321,951,284,853.25	1,003,667,612,515.00
4	Валютын ханшийн зөрүү	(290,310,931.37)	49,845,511.19
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	219,071,609,176.98	734,521,356,767.19
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	142,882,487,106.88	361,954,096,283.86
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	361,954,096,283.86	1,096,475,453,051.05

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж, шалгуур	Хүрэх үр дүн	Гүйцэтгэлийн хувь
1	Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах	Тэрбум төгрөг	2,017.5	0.3%
2	Ажлын байр бий болгох	Ажлын байрны тоо	100	-
3	Уур амьсгалын ногоон сангийн магадлан итгэмжлэл авах	Магадлан итгэмжлэл авах		100.0%
4	Ногоон тогтвортой санхүүжилтийн дамжуулан хөтөлбөр хэрэгжүүлэх, ногоон зээлийн багц бүрдүүлэх, дамжуулан хөтөлбөр хэрэгжүүлэх	Нийт зээлийн багцад эзлэх хувь	5.0%	10.0%
7	Баталгаа, батлан даалт гаргах	Сая ам.доллар	50.0	0.0%
8	Төрөлжсөн байдлаар урт хугацаатай эх үүсвэрийг татан төвлөрүүлэх	Сая ам.доллар	800.0	62.5%
9	Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчныг олон улсад таниулан сурталчилж гадаадын хөрөнгө оруулалтын байгууллага, сангуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах;	Гэрээний тоо	5	85.0%
10	Хуваарийн дагуу эргэн төлүүлэх	Тэрбум төгрөг	310.0	40.9%
11	Чанаргүй активт хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу эргэн төлүүлэх	Тэрбум төгрөг	743.4	11.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна гэж заасан байна.

МУХБ 2025 онд “Санхүүгийн үзүүлэлтээ тогтворжуулах, олон улсын итгэлийг сэргээх” зорилт дэвшүүлэн ажиллаж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, хөгжлийн санхүүжилтийг сэргээх суурь нөхцөлөө бүрдүүлэх, эрсдэлтэй активын хэмжээг бууруулж, санхүүгийн үзүүлэлтээ сайржуулах зорилгоор МУЗГ-ын шийдвэрүүдийг гаргуулан ажилласан байна.

МУХБ 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн үзүүлэлтийн хувьд 1,096,475.5 сая төгрөгтэй тэнцэх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөтэй, 138,422.8 сая төгрөгийн татварын дараах алдагдалтай ажиллаж, нийт хөрөнгө 3,211,788.2 сая төгрөг байна. Тайлант онд 165,812.7 сая төгрөгийн хүүгийн орлоготой, 240,993.0 сая төгрөгийн хүүгийн зардалтай ажиллаж, чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт (NPL) 54.8 хувь, өөрийн хөрөнгийн хүрэлцээ 1.9 хувьд хүрсэн байна.

Батлагдсан бизнес төлөвлөгөөгөөр 2025 онд гэрээний дагуу 17,500.0 сая төгрөг, шинээр 2,000,000.0 сая төгрөг, нийт 2,017,500.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн боловч 6,764.3 сая төгрөгийн санхүүжилтийг “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д олгосон байна.

Санхүүжилтийн хүсэлт ирүүлсэн нийт 5,800,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төслийн хүсэлтийг хүлээн авч МУХБ-ны тухай хууль болон бодлого журмын шаардлага хангаж буй Бөөрөлжүүт цахилгаан станцын 2 дахь үе шатны 300 МВт-ын төсөлд 300.0 сая ам.доллар, Багахангай хөшгийн хөндий 102.8 км салбар төмөр замын төсөлд 720,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгох төслийг судлах судалгааны баг томилж, төслийн шийдвэр гаргах үе хүртэлх бэлэн байдлыг хангуулсан байна.

МУХБ нь 2025 оны жилийн эцсийн байдлаар 2,812,853.2 сая төгрөгийн урт хугацаат эх үүсвэрийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд эдгээр эх үүсвэр нь БНХАУ-ын Хөгжлийн банк, Сангийн яам болон дотоодын бондын зах зээл, олон улсын зах зээлд арилжаалсан бондуудаас бүрдэж байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

МУХБ-ны тухай хуульд өөрчлөлт ороогүй бөгөөд МУХБ-нд бүртгэлтэй зээл, өр төлбөрийг барагдуулахтай холбоотой МУЗГ-ын дараах шийдвэрүүд гарсан байна. Үүнд:

- МУЗГ-ын 2025 оны 32 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаатай зээл, үнэт цаасны төлбөр, УИХ-ын баталсан бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төслүүд, орон нутагт хэрэгжүүлсэн бодлогын хөтөлбөрийн дагуу санхүүжүүлсэн зээл активуудын төлбөр тооцооны асуудлыг нэг бүрчлэн хэлэлцэж, МУЗГ-ын шийдвэрээр эзэнжүүлэх, төрийн өмчит хуулийн этгээд, Нийслэл, Хөгжлийн банкны хооронд үүссэн хөрөнгө оруулалт, үнэт цаас, авлага, өглөгийг шийдвэрлэх чиглэлийг үүрэг болгосон;
- МУЗГ-ын 2025 оны 137 дугаар тогтоолоор МУЗГ-ын 2025 оны 32 тогтоолын 1.1.2 дахь заалтад тусгасан “ТОСК БОНД”-ын барьцааг худалдаж, төлбөрт авах нөхцөлийг хүчингүй болгосон;
- МУЗГ-ын 2025 оны 195 дугаар тогтоолоор банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг 1.5 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн болон давуу эрхийн хувьцаа гаргаж, Эрдэнэс Монгол ХХК-ийн харьяа хуулийн этгээдэд эзэмшүүлэх, хувьцааны төлбөрт Эрдэнэс Монгол ХХК-аас үнэт цаас гаргаж МУХБ-нд эзэмшүүлэх, мөн уг үнэт цаасны төлбөрт төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс үүссэн авлагыг МУХБ-нд шилжүүлэх

зэрэг арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн байна. Тогтоолын дагуу Эрдэнэс Монгол ХХК-тай гэрээг эцэслэх ажлууд хийгдэж байгаа ч хэрэгжилт хангагдаагүй байна.

Тайлант хугацаанд МУХБ-ны үндсэн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Банкны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

ТУЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 48 дугаар тогтоолоор МУХБ-ны зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан бөгөөд Дотоод аудитын газрыг 8 орон тоотой байхаар баталсан байна.

Тайлант онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 9 дотоод аудитаар 14 нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, ТУЗ-ийн хуралд танилцуулах асуудалд санал дүгнэлт боловсруулах, танилцуулга хийхтэй холбоотой 14 ажлыг тус тус гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын газар нь аудитын зөвлөмжийн программ ашигладаг бөгөөд түүнд 232 төрлийн зөвлөмж бүртгэлтэй байгаа бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тайлагнах хугацаа болсон 132 төрлийн зөвлөмжийн хэрэгжилт 58.0 хувьтай буюу хэрэгжих шатанд байна гэж үнэлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

МУХБ 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/121¹ дүгээр тогтоолоор "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг баталсан байна.

Тус банкны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, банкны үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

МУХБ-ны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой хууль, журам, бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 934,259.9 сая төгрөгөөр буюу 41.0 хувиар өссөн байна.

¹ Монгол Улсын Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/121 дүгээр "Бодлого, заавар батлах тухай" тогтоол

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	361,954.1	1,096,475.4	734,521.3
Хөрөнгө оруулалт	356,835.0	560,303.0	203,468.0
Зээл (цэвэр дүнгээр)	1,294,322.8	1,296,200.4	1,877.6
Дериватив санхүүгийн хөрөнгө	2,560.0	14,039.9	11,480.0
Бусад санхүүгийн хөрөнгө	162,132.3	210,007.1	47,874.7
Бусад санхүүгийн бус хөрөнгө	642.1	10,420.0	9,777.6
Үндсэн хөрөнгө	22,336.9	21,617.7	(719.1)
Борлуулах зориулалттай хөрөнгө	76,508.6	2,467.0	(74,041.6)
Биет бус хөрөнгө	236.4	257.9	21.5
Нийт хөрөнгө	2,277,528.2	3,211,788.2	934,260.0
Харилцах	3,160.7	7,995.1	4,834.4
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	453,752.3	268,269.8	(185,482.5)
Бусад эх үүсвэр	1,392,012.5	2,604,579.6	1,212,567.3
Дериватив санхүүгийн өр төлбөр	1,382.0	29,146.1	27,764.2
Бусад санхүүгийн өр төлбөр	2,759.3	7,264.8	4,505.4
Бусад санхүүгийн бус өр төлбөр	36,649.8	44,196.2	7,546.3
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,216,300.3	1,216,300.3	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	26,276.5	27,224.3	947.7
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(854,765.2)	(993,188.0)	(138,422.8)
Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	2,277,528.2	3,211,788.2	934,260.0

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө, бусад эх үүсвэр дансдад дараах материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Тухайлбал,

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,096,475.4 сая төгрөг болж 734,521.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 500.0 сая ам.долларын татан төвлөрүүлсэн хөрөнгийг хадгаламжид байршуулсантай холбоотой;
- Хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 560,303.0 сая төгрөг болж, 203,468.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2025 онд банк нийт 51.2 сая ам.доллар буюу 183,500.8 сая төгрөгийн үнэт цаас худалдан авсантай холбоотой ба үүний 9.5 сая ам.доллар буюу 34,048.0 сая төгрөг нь засгийн газрын үнэт цаас, үлдсэн нь банк гаргасан үнэт цааснаасаа худалдан авсантай холбоотой;
- Дериватив санхүүгийн хөрөнгө, өр төлбөр өссөн нь Монгол банктай хийсэн нийт 200.0 сая ам.долларын своп хэлцлийн ханшийн зөрүүтэй холбоотой;
- Бусад санхүүгийн хөрөнгө 210,007.0 сая төгрөг болж, 47,874.7 сая төгрөгөөр өссөн нь НОСК, ТОСК-ийн (Буянт-Ухаа, Орхон, Хөвсгөл, Говь-Алтай) ӨБҮХХ дээр бүртгэлтэй байсан хөрөнгийг авлага руу ангилсантай холбоотой;
- Бусад санхүүгийн бус хөрөнгийн 9,777.6 сая төгрөгийн өсөлт нь дээрх НОСК, ТОСК-ийн (Буянт-Ухаа, Орхон, Хөвсгөл, Говь-Алтай) ӨБҮХХ дээр бүртгэлтэй байсан хөрөнгийг авлага руу ангилахдаа үүнтэй холбоотой НӨАТ-ийн авлагыг бүртгэснээс үүссэн;
- Борлуулах зориулалттай хөрөнгийн үлдэгдэл 2,467.0 сая төгрөг болж, 74,041.6 сая төгрөгөөр буурсан нь 2024 оны эцсээр Шинэ яармагийн борлуулах зориулалттай хөрөнгөнд бүртгэлтэй байсан орон сууцуудыг 2025 онд ангиллын залруулга хийн өмчлөх бусад хөрөнгөнд бүртгэсэнтэй холбоотой.
- Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн 185,482.5 сая төгрөгийн бууралт нь банк 2025 онд БНХАУ-ын Хөгжлийн Банкнаас 2021 онд авсан 400 сая юанийн зээлээс 26.9 сая юань буюу 13,165.1 сая төгрөгийг, ОХУ-ын Внешэконом банкнаас авсан 2018, 2019 оны зээлүүдийн үндсэн төлбөр болох нийт 35.1 сая евро буюу 132,361.4 сая төгрөгийн зээлийн төлбөрийг тус тус барагдуулснаас шалтгаалсан;
- Бусад эх үүсвэр 1,212,567.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь банк 2025 онд 500.0 сая ам долларыг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2², 21 дүгээр зүйлийн 21.6.1³-д заасны дагуу банкны стратегийн зорилт, урт, дунд хугацааны болон тухайн жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

МУХБ-ны ТУЗ-ийн 2024 оны 36⁴ дүгээр тогтоолоор банкны 2025 оны Бизнес төлөвлөгөөг баталсан байна. МУХБ-ны бизнес төлөвлөгөөг үндсэн 8 стратегийн зорилгын хүрээнд 3 зорилго, 26 дэд зорилтыг баталсан байна.

Хүснэгт 2. МУХБ-ны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт

№	Зохистой харьцааны үзүүлэлт	Хязгаарлалт	2024.12.31	2025.12.31
1	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	≥9%	9.5%	1.9%
2	Тогтвортой санхүүжилтийн харьцаа	≥100%	120.3%	164.4%
3	Нийт гадаад валютын нээлттэй позиц/ӨХ	≤ ±30%	-19.4%	-60.5%
4	Том зээлийн багц/нийт багц	≤80%	88.7%	92.1%
5	Чанаргүй зээлийн харьцаа	≤10%	57.4%	54.8%

Эх сурвалж: МУХБ

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 7.1 пунктээр бага байгаа нь эрсдэлийн сан нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд банкыг мөнгөжүүлэх шаардлагатайг харуулж байна. Нийт гадаад валютын нээлттэй позиц -60.5 хувьд хүрсэн нь гадаад валютаар төлөх өр төлбөр өндөр байгааг харуулж, ханшийн алдагдал хүлээж болзошгүй эрсдэлтэй байна. Нийт зээлд эзлэх төвлөрөл 92.1 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 54.8 хувьд хүрсэн нь МУХБ үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй, дампуурах эрсдэлтэй байна.

МУХБ-ны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкны санхүүгийн тайлан болон гол харьцаа үзүүлэлт дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Орлогын тайлан

/сая төгрөгөөр/

Орлогын үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
Хүүгийн орлого	272,800.0	165,812.8	60.7%
Хүүгийн зардал	(304,500.0)	(240,993.1)	79.1%
Хүүгийн цэвэр орлого/(зардал)	(31,700.0)	(75,180.3)	237.2%
Эрсдэлийн сангийн (зардал)	207,000.0	18,790.7	13.6%
Үнэ цэнийн бууралтын дараах хүүгийн цэвэр орлого	(69,100.0)	(56,389.6)	-81.6.0%
Арилжааны ашиг/алдагдал	1,000.0	(8,771.3)	-331.4%
Ханшийн тэгшитгэлийн ашиг/алдагдал	(66,400.0)	(16,322.1)	63.8%
Шимтгэл хураамжийн орлого/зардал	(1,600.0)	(744.5)	46.8%
Үйл ажиллагааны зардал	(23,500.0)	(18,892.3)	80.9%
Бусад орлого/зардал	16,400.0	65,293.3	-69.3%
Татварын өмнөх ашиг/алдагдал	26,500.0	(138,164.6)	-521.1%
Орлогын албан татварын зардал/буцаалт	(16,900.0)	(258.2)	1.5%
Татварын дараах ашиг/алдагдал	9,600.0	(138,422.8)	-1441.6%

Хүүгийн орлого төлөвлөсөн түвшинд хүрээгүй 165,812.7 сая төгрөгийн буюу 60.7 хувийн гүйцэтгэлтэй, татварын дараах алдагдал төлөвлөсөн түвшнээс 128,822.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

МУХБ-ны 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 23,522.4 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүний 66.0 хувийг боловсон хүчинтэй холбоотой зардал, 34.0 хувийг үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал эзэлж байна.

Үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 18,612.0 сая төгрөг буюу 70.6 хувьтай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгааны үр дүнгийн талаар :

² 20.1.2 Хөгжлийн банкны тухайн жилийн бизнес төлөвлөгөөг батлах,

³ 21.6.1.Хөгжлийн банкны үйл ажиллагааны дунд, урт хугацааны стратеги, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх,

⁴ Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 36 дугаар "Монгол Улсын Хөгжлийн банкны 2025 оны бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны зардлын төсөв, үндсэн хөрөнгө худалдан авах төсвийг батлах тухай" тогтоол.

1. Компанийн орон тооны цомхотголын талаар:

МУЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэл, ЭЗХС-ын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01/3430 дугаар "Удирдамж өгөх тухай" албан бичгийг үндэслэл болгон ТУЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 48 дугаар тогтоолоор МУХБ-ны зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлахдаа орон тоог 46, газрын тоог 4, хэлтэс нэгжийн тоог 9 -өөр цөөлж цомхотгосон. Тус бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 2025 онд 12 ажилтанд 155.8 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Тус банк нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А/81 дүгээр тушаалаар нэг өдрийн унааны хөнгөлөлтийг 5,000.00 төгрөг, хоолны хөнгөлөлтийг 20,000.00 төгрөгөөр баталж, тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтөд гүйцэтгэлээр 670.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн, форумын үйл ажиллагаанд гүйцэтгэлээр 219.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

4. Гадаад томилолтын судалгааны үр дүн:

Тайлант онд гадаадад 18 удаагийн, дотоодод 29 удаагийн албан томилолтоор ажиллаж, 674.7 сая төгрөг төсөвлөснөөс 540.8 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

5. Хэвлэл мэдээллийн судалгааны үр дүн:

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр банк, үйл ажиллагаагаа сурталчлах болон цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх зорилгоор 147.8 сая төгрөг зарцуулсан байна.

6. Программ хангамжийн судалгааны үр дүн:

МУХБ нь үйл ажиллагаандаа 70 нэр төрлийн программуудыг ашигладаг бөгөөд тайлант онд компьютерын хэрэглээний программын болон вирусийн хамгаалалтын программын жилийн үйлчилгээний хураамжид 1,374.3 сая төгрөг төлөвлөснөөс 1,175.8 сая төгрөг төлсөн байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу МУХБ-ны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн нягтлан бодох бүртгэл болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитын багийн аудитор Д.Зэндмэнэ, М.Доржханд, Б.Бүрэнхүү, Б.Буянхишиг, ахлах аудитор Ч.Ариунаа, аудитын менежер Б.Золбаяр, Б.Өлзий, П.Ундармаа, И.Туяадарь нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын багийн ахлах, гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер Б.Саруул, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

МУХБ 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 2/199 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн тайлан, суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгө 387,811.7 сая төгрөгөөс 0.5 хувиар тооцож 1,939.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 124.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд 124.3 сая төгрөгийн 4 албан шаардлага, 1 зөвлөмжийг тус тус хүргүүллээ. Үүнд:

Илрүүлэлт 1.

МУХБ-ны үйл ажиллагаа, санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагатай 4.0-4.9 сая төгрөгийн 9 гэрээ байгуулж, нийт 34.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т заасан *Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхийг хориглоно* гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент зэрэгт санхүүжилт олгохгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2.

МУХБ-аас 2024 оны үйл ажиллагааны тайланг монгол, англи хэлээр 170 ширхэг, хураангуй буюу гарын авлагыг монгол, англи хэлээр 290 ширхэг хэвлүүлэхээр 11.0 сая төгрөгийн 2 гэрээг Монголын үнэт цаас ХХК, СМҮК ХХК-тай байгуулсан байна. Тайлан, гарын авлагыг 2025 оны 4, 9 дүгээр сард хэвлүүлсэн бөгөөд их хэмжээгээр хэвлэж, тараах, зайлшгүй хэрэгцээ шаардлага тогтоогдоогүй, түүнчлэн бүртгэлд бүртгэн хүлээн авсан, зарлагадсан санхүүгийн баримт байхгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д заасан Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”-ийг хориглох гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Хэрэгцээ шаардлагыг тооцолгүйгээр тараах материал хэвлүүлсэн зөрчлийг таслан зогсоож, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д заасан Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”-ийг хориглох гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 3.

МУХБ-ны гүйцэтгэх захирлын “Чиг үүрэг, орон тоо шинэчлэн батлах тухай” 2025 оны А/4 дүгээр тушаалд заасан "Банкны үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж, ажил, үйлчилгээний талаарх мэдээлэл, жилийн тайланг гаргах, мэдээг цахим хуудас, нийгмийн сүлжээгээр дамжуулан нийтэд түгээх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах" гэсэн чиг үүрэг нь тус банкны Маркетинг, олон нийттэй харилцах хэлтэст хамааралтай байхад 2025 онд шинээр хийлгэсэн цахим хуудас болон брэндбүүкийг байгууллагын ажилтнууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад танилцуулж, сурталчлах, контент бэлтгэх ажлыг 2.2 сая төгрөгөөр 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд гүйцэтгүүлэхээр Түшиг арвин үйлс ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, тайлант онд хэвлэл захиалгын төлбөрт 1.1 сая төгрөг, нийт 3.3 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т заасан *Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх* гэсэн хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, 12 дугаар зүйлийн 12.1.3-т *хэвлэлийн захиалгын төлбөр* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, хэвлэл захиалга, контент бэлтгэх зардлыг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 4.

"Банкир 2025", Эдийн засаг, хөгжлийн сайдын нэрэмжит тэмцээн, уралдааныг зохион байгуулахад 30.1 сая төгрөг, "Зочин төлөөлөгчийн зардал" нэрээр кофе, ус ундаа, чихэр, жимс зэргийг худалдан авахад 45.0 сая төгрөг, нийт 75.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т *хуулиар зөвшөөрөөгүй бусад*, 15 дугаар зүйлийн 15.1.8-д *байгууллагын төсвөөр биеийн тамир*,

спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, Төсвийн тухай хуулийн 24.7-д Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно гэж заасантай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг талсан зогсоож, биеийн тамир, уралдаан тэмцээн зохион байгуулах ажлыг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 5.

Байгууллагын цахим хуудаст ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлын ажлын байранд тавигдах шаардлага, гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгасан эсэх шийдвэр, компанийн 2025 онд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, ЭМДШ, НДШ-ийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна, 20.3-т Энэ хуулийн 15.4-т заасан гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна, 20.4-т Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдэд ногдуулсан аливаа акт, албан шаардлага, зөрчлийн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэр, гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулж байх зөвлөмж өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан гүйцэтгэл, нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан гүйцэтгэл, нийцлийн асуудлаар нийт 559,334.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 559,143.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 191.9 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах нийт 64 тушаал шийдвэрээс 1,663.6 сая төгрөгийн 53 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний нийт 114 гүйлгээнээс 132.7 сая төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй, 4,454.1 сая төгрөгийн 80 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг ил тодоор мэдээлэх нийт 73 мэдээллээс 2,804.2 сая төгрөгийн 53 мэдээллийг нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*, 6 дугаар зүйлийн 6.4.4-т *5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*, 6.4.5-д *цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*, 6.4.8-д *...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд зааснаар МУХБ-ны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн байх ёстой хэдий ч Алсын хараа 2050, Таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах, төсөлд санал авах, батлуулах, хэрэгжүүлэх үе шатанд МУХБ хэрхэн оролцож хамтран ажиллах талаар эрх зүйн ямар нэгэн зохицуулалтгүй, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 23.2-т УИХ, Засгийн газар МУХБ-ны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй байхаар, харин Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан тусгахаар, 20.2-т эх үүсвэрүүдийг дурдаж өгсөн ч Хөгжлийн банкны эх үүсвэрийг ашиглах эсэх нь тодорхой тусгагдаагүй зэргээс “үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх” хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Хөгжлийн банк санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрөө хэрхэн яаж сонгох нь тодорхойгүй хэвээр байна.

Өмнөх хугацаанд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь МУЗГ-ын тогтоол, шийдвэрээр, МУЗГ-аас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийг дэмжсэн агуулгатай төслүүд байгаа ч төрийн бодлогыг хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцдаггүйгээс тэдгээр төслүүдийн хэрэгжилт хангалтгүй, чанаргүй ангилалд бүртгэгдэж, өр төлбөр нь хугацаандаа төлөгдөхгүй байна.

МУХБ богино хугацаатай арилжааны нөхцөлтэй эх үүсвэрээр урт хугацаанд хэрэгжих төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх өнөөгийн загвараар 15 жилийн турш үйл ажиллагаагаа явуулж байгаа нь үр дүнд хүрээгүй байна. МУХБ 2025 онд хууль эрх зүйн орчныг шинэчлэхээр хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт өргөн барьсан боловч эцэслэн хэлэлцэгдэж батлагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай уялдуулах байдлаар шинэчлэх саналыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх, үйл ажиллагааны загварыг өөрчилж, урт хугацаат эх үүсвэрээр төсөл хөтөлбөр санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлэх зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 2.

Банкны өөрийн хөрөнгө багасаж байгаатай холбоотойгоор гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргалт хумигдаж, банкны ихэнх шийдвэр ТУЗ-ийн хурлаар гарч, нэг талд төвлөрч, банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ТУЗ-ийн оролцоо нэмэгдэж, гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг багассан байна. Энэ нь олон шат дамжлагаар шийдвэр гаргалт удаашрах нөхцөлийг бүрдүүлж, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, 2025 онд олон улсын зах зээлд арилжаалсан 500.0 сая ам.долларын эх үүсвэрийг зээл олголтод гаргах шийдвэр гаргаагүй, жилийн эцсийн байдлаар уг эх үүсвэр мөнгөн хадгаламжид байршиж байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, МУХБ-ны дүрмийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 3.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хавсралт 1-ийн дагуу 9 зарчим тус бүрийн хүрээнд үнэлгээг хийхэд МУХБ-ны засаглал "хангалтгүй" үнэлгээтэй байна.

Шалтгаан нь МУХБ нь ТУЗ-ийн залгамж халааны бодлогыг боловсруулж, үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг дэлгэрэнгүй тусгаж, үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй, ТУЗ нь дэргэдэх хороодоор дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эцсийн хариуцлагыг хүлээдэг боловч аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо, эрсдэлийн хороодын үйл ажиллагааны журмыг тусгайлан батлаагүй, нээлттэй мэдээллийг байнга ил тод байлгах үүргээ хэрэгжүүлээгүй, олон нийтэд ил тод мэдээлж буй байгууллагын үйл ажиллагааны тайланд хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэх зэрэг мэдээллийг иж бүрнээр нь тусгаагүй, ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг батлаагүй, мөн тус банкны дүрэмд ТУЗ-ийн гишүүдийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнд суурилсан шалгуурыг бүрэн тусгаагүй, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь Гүйцэтгэх захиралтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээ, түүний үр дүнг жил бүр дүгнэж ТУЗ-д танилцуулах чиг үүрэгтэй ч Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч он дуусахаас өмнө чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор хөдөлмөрийн гэрээний үр дүнг үнэлж, дүгнээгүй, МУХБ-ны гүйцэтгэх удирдлага, тэргүүн дэд захирал, газрын захирлуудыг хуульд заасны дагуу сонгон шалгаруулах журмыг батлаагүй зэрэгтэй холбоотой байна.

Энэ зөрчил нь өмнөх хугацаанд ч оршин байсан бөгөөд одоо ч хэвээр байна. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4⁵, 21 дүгээр зүйлийн 21.3⁶, 21.4⁷ дэх заалтуудыг зөрчиж байна.

⁵ 20.1.4.Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах журам батлах, түүнтэй гэрээ байгуулах, дүгнэх;

⁶ 21.3.Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, газрын захирлуудыг энэ хуулийн 20.1.4-т заасан журмын дагуу олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож, төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж, чөлөөлнө.

⁷ 21.4.Гүйцэтгэх захирал нь дараах шаардлагыг хангасан байна:

21.4.1.банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, санхүүгийн салбарт удирдах албан тушаалд таваас доошгүй жил ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх;

21.4.2.ял шийтгэлгүй, ёс зүй болон бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харшлахгүй байх;

21.4.3.төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон бусад шаардлага.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг арилгахын тулд ТУЗ-д дараах зөвлөмжүүдийг өглөө. Үүнд:

- ТУЗ-ийн дэргэдэх хороодын журмыг баталж, хэрэгжүүлж ажиллах;
- МУХБ-ны Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал, газрын захирлуудыг улс төрөөс ангид, мэргэжлийн этгээд сонгох, тэдгээртэй гэрээ байгуулж, дүгнэх, хууль тогтоомжид заасныг хэрэгжүүлээгүйн улмаас компанид учирсан хохирол, зөрчлийн хариуцлагыг бүрэн хүлээдэг байх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;

Илрүүлэлт 4.

МУХБ-ны гүйцэтгэх удирдлага, нэгжийн удирдлагуудыг нээлттэй сонгон шалгаруулалт явуулахгүйгээр үүрэг гүйцэтгэгчээр шууд томилж байгаа нь хуулийн өмнө хүн бүр тэгш боломжоор хангагдах зарчмыг алдагдуулж, байгууллагын удирдлагын тогтворгүй байдлаас томилогдсон удирдлага бүр байгууллагын үйл ажиллагаа, ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийлгүйгээр бүтцийн өөрчлөлт хийж байгаагаас чиг үүргийн давхардал, хийдэл ажиглагдаж, ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах байдал хангалтгүй байна.

МУХБ нь 2023-2025 онд 6 ажилтныг ажлаас үндэслэлгүйгээр халсан нь шүүхээр тогтоогдож, 2023 онд 1 ажилтанд 172.3 сая төгрөг, 2024 онд 4 ажилтанд 270.4 сая төгрөг, 2025 онд 1 ажилтанд 36.1 сая төгрөг, нийт 478.9 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 2025 онд 12 ажилтанд 155.8 сая төгрөгийн нөхөн олговор олгож, үргүй зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь:

МУХБ-ны чиг үүргийн шинжилгээ хийсний дараа бүтцийн өөрчлөлтийг хийх, нэг бүтцээр тогтвортой ажиллах, ажилтан албан хаагчдын чиг үүргийг ажлын ачаалалтай уялдуулан зохистой хуваарилах зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 5.

МУХБ-ны үйл ажиллагааг дунд хугацаанд чиглүүлэх тодорхой стратеги бүрэн тодорхойлогдоогүй байхад 2025 оны бизнес төлөвлөгөөнд зээлийн багцыг 50.0 хувиар нэмэгдүүлж, 2,000,000.0 сая төгрөгийн шинэ зээл олгохоор, олон улсын зах зээлээс 800.0 сая ам.долларын эх үүсвэр татахаар төлөвлөсөн байна. Гэвч тайлант онд шинээр зээл гаргаагүй, 500.0 сая ам.долларын эх үүсвэр татсан ч зээл олгоогүй зэргээр төлөвлөсөн түвшинг хангаагүй байна. Энэ нь дунд хугацааны стратеги зорилтоо тодорхойлоогүй, төлөвлөлтийн бодит байдал, хэрэгжилтэд тавих удирдлага, зохион байгуулалт, хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүйтэй холбоотой байна.

МУХБ-ны удирдлага Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1⁸, МУХБ-ны дүрмийн 6.3⁹-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хөгжлийн банкны дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөөг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан батлах, МУХБ нь ТУЗ-өөс баталсан урт дунд хугацааны стратеги төлөвлөгөө, тухайн жилийн бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулах, үйл ажиллагааг сэргээх, ашигт ажиллагааг хангаж ажиллах зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 6.

Тайлант онд 33 зээл бүртгэлтэй байгаагаас 25 зээл чанаргүй ангилалд шилжсэн нь зээлийн багцын чанар эрс муудсанаас хүүгийн зардал нь хүүгийн орлогоос давж, банкны алдагдал цаашид нэмэгдэх нөхцөл бүрдсэн байна. Энэ нь зээлийн эрсдэлийн удирдлага,

⁸ 20.1.1.Хөгжлийн банкны дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөөг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан батлах;

⁹ Банк нь ТУЗ-өөс баталсан урт дунд хугацааны стратеги төлөвлөгөө, тухайн жилийн бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулна.

зээл олголт болон хяналтын тогтолцоо хангалтгүй байсныг харуулж байгаа бөгөөд банкны санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэл үүссэн байна. Барьцаа хөрөнгө хангалтгүй байхад ирээдүйд бий болох хөрөнгө барьцаалж зээл олгож байгаа нь тухайн тоног төхөөрөмжийг гэрчилгээжүүлж, барьцааны гэрээг нөхөж хийх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, Газ Импорт ХХК, Дэд бүтэц инженеринг ХХК, Моннис майнинг ХХК, Зэст-Өндөр ХХК зэрэгт олгосон зээлийн LTV харьцаа буюу зээл барьцаа хөрөнгийн харьцаа алдагдсан байна. Мөн ТОСК ТӨХХК Засгийн газрын шийдвэрийн дагуу барилга барих хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг худалдан авснаар тоног төхөөрөмжийн үнэ болох ... сая төгрөг эргэн төлөөгүй, ирсэн тоног төхөөрөмжийг Батлан хамгаалах яамны данс бүртгэлд бүртгээгүй, ашиглаагүй, үхмэл хөрөнгө болсон байна.

Зээлийн багцын чанарыг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, зээлийн эрсдэлийн удирдлага болон хяналтын тогтолцоо хэлбэрийн хувьд байгаа ч үр нөлөөгүй байна. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6.3¹⁰, 21.6.6¹¹-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь:

Зээлийн эрсдэлийн удирдлага, зээл олголт болон хяналтын тогтолцоог дахин шинэчлэх, өмнөх зээлүүдийн олголт дээр үүссэн эрсдэлд дүгнэлт гарган, цаашид зээл олголтын эрсдэлийг бууруулж хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, эх үүсвэрийн чөлөөт үлдэгдлийг зах зээлд хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгсэлд үр өгөөжтэй байршуулах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх заалтыг мөрдөж, өмнөх 2019 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах, зээлийн үлдэгдлийг хугацаа алдахгүй барагдуулах арга хэмжээ авах зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 7.

Тайлант онд МУХБ 500.0 сая ам.долларын үнэт цаасыг гадаад зах зээлд 8.5 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатайгаар 2025 оны 7 дугаар сарын 03-ны өдөр гаргасан байна. Татан төвлөрүүлсэн эх үүсвэрээс DBM2026 бондын 122.3 сая ам.долларыг хугацаанаас нь өмнө 11.0 хувийн хүүгийн өгөөжтэй дахин санхүүжүүлсэн байна. Эх үүсвэрийн үлдэгдэл 377.7 сая ам.долларыг банк зээл гаргаагүй, бүрдүүлсэн эх үүсвэрийн хүүгээс бага хүүтэй буюу 3.5-6.0 хүүтэй хадгаламжид байршуулж байна.

Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6.9¹²-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

МУХБ-ны үндсэн үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулж ажиллах зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 8.

Тайлант хугацаанд Монгол банк болон Засгийн газраас хийсэн ээлжит хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг ДАГ-аас Монгол банкны хувьд 71.4 хувь, Засгийн газрын шалгалтын хэрэгжилт 16.7 хувьтай гэж үнэлсэн байна. Мөн Дотоод аудитын газраас 2025 онд 9 сэдвийн хүрээнд аудит хийж зөвлөмж хүргүүлсэн боловч зөвлөмжийн хэрэгжилт 58.0 хувь байгаа нь дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах удирдлагын хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

¹⁰ 21.6.3.санхүүгийн сахилга батыг сахиулах, Хөгжлийн банкны хэвийн үйл ажиллагааг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

¹¹ 21.6.6.зээлийн болон дотоод хяналт, шалгалтын тогтолцоо бүрдүүлэх;

¹² 21.6.9.хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж, эх үүсвэрийн чөлөөт үлдэгдлийг зах зээлд хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгсэлд үр өгөөжтэй байршуулах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6.3¹³-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хөндлөнгийн болон дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх үр нөлөөтэй хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллах зөвлөмж өглөө.

Илрүүлэлт 9.

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь Ди Би Эм лизинг ХХК, Ди Би Эм ассет менежмент ХХК охин компаниудыг үүсгэн байгуулж, хувьцааг 100 хувь эзэмшдэг бөгөөд дээрх компаниудын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар хувьцаа эзэмшигчийн үүргээ бүрэн биелүүлээгүй, охин компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал,

- МУЗГ-аас АХБ-тай байгуулсан буцалтгүй тусламжийн гэрээний хүрээнд хэрэгжсэн Ди Би Эм ассет менежмент ХХК-ийн Касталиа лимитед ХХК-тай байгуулсан гэрээнд заасан хяналтыг МУХБ-аас хэрэгжүүлээгүй, төсөл хугацаандаа үр дүнтэй хэрэгжээгүй;
- Ди Би Эм ассет менежмент ХХК 2023-2025 онд үндсэн үйл ажиллагаанаасаа орлого олоогүй, Ди Би Эм лизинг ХХК нь 2025 онд үндсэн үйл ажиллагаа болох санхүүгийн түрээсийн шинэ зээл санхүүжүүлээгүй, хүүгийн орлого олох боломжийг эрэлхийлж ажиллаагүй, мөнгөн хөрөнгийг арилжааны банкны хадгаламжид байршуулах замаар үйл ажиллагаа явуулж байгаа нь компанийг байгуулсан зорилго зорилттой нийцэхгүй байхад компанийн ТУЗ компанийн үйл ажиллагааг сайжруулах, орлого, ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ аваагүй;
- Ди Би Эм ассет менежмент ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 02 дугаар сараас хойш хараат бус гишүүнгүй үйл ажиллагаа явуулж, хараат бус гишүүний оролцоог хангаагүй, Төлөөлөн удирдах бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүй үедээ 18 тогтоолыг баталсан;
- Ди Би Эм ассет менежмент ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Тэмүүжинг МУХБ-ны Хөрөнгийн удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгчийн ажлыг давхар гүйцэтгүүлж, мөн МУХБ ХХК-тай Олон улсын зах зээлд үнэт цаас гаргах үйл ажиллагааны хүрээнд хаалттай бонд гаргах тохиромжит бүтцийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид банкны investor deck-ийг танилцуулах, хөрөнгө оруулагчийн магадлан шинжилгээний асуудалд хариулах, хөрөнгө оруулагчтай хэлэлцээрт орох, бусад санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх боломжийг судлах, эх үүсвэрийг эрэлхийлэн холбогдох зөвлөгөөг өгөх хөлсөөр ажиллах гэрээг 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс 2 сарын хугацаатай байгуулж, 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн гэрээг 2 сараар сунган ажиллуулж, нийт 2024-2025 онд 88.3 сая төгрөгийн цалин, хөлс олгосон. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д *Энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр 4.1.3-т төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан* гэж заасны дагуу Ди Би Эм ассет менежмент ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Л.Тэмүүжингээр давхар ажил эрхлүүлж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т *Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ*

¹³ 21.6.3.санхүүгийн сахилга батыг сахиулах, Хөгжлийн банкны хэвийн үйл ажиллагааг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно*, Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т *Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй*, 6 дугаар зүйлийн 6.13-т *Төр болон бусад хуулийн этгээд аливаа компанид хөрөнгө оруулсныхаа төлөө эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээ хэрэгжүүлэхдээ дүрэмдээ заасан эрх бүхий этгээдээс томилсон төлөөлөгчөөр дамжуулан төлөөллөө хэрэгжүүлэх бөгөөд энэхүү төлөөлөгч нь уг төлөөллийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль болон тухайн компанийн дүрэмд заасан эрх бүхий этгээдээс өгсөн удирдамжийг үндэслэх ба энэхүү удирдамжаас өөрөөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэслэл болно*, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-т *Ажил олгогч, ажилтны хоорондын харилцаа нь энэ хуулийн 4.1.15-д заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжтэй бол хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно. Хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулсан боловч уг харилцаа нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжийг агуулсан бол түүнийг хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцно* гэж заасантай нийцэхгүй, мөн охин компаниудын дүрэмд заасан Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, компанийн Төлөөлөн удирдах зөвлөл эрх, үүргээ хэрэгжүүлж охин компаниудын орлого, ашгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд идэвх санаачилгаатай оролцох, компани бие даасан, үр ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлээгүй, компанийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн аливаа бодлого, шийдвэрийг дэмжиж ажиллаагүй, компанийн хараат бус гишүүнийг өөрийнх санаачилгаар чөлөөлсөн ч орны гишүүнийг түр болон бусад байдлаар урт хугацаанд томилоогүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн охин компаниуд болох Ди Би Эм ассет менежмент ХХК, Ди Би Эм Лизинг ХХК-ийн үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлөөр дамжуулан үйл ажиллагааг хянан удирдаагүй, ТУЗ-ийн хараат бус гишүүнийг томилоогүй, давхар ажил эрхлүүлсэн, үр нөлөөтэй хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй, засаглалын үзүүлэлтүүд хангалтгүй байгаад хяналт тавиагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлээ.

Илрүүлэлт 10.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т *Монгол Улсын Хөгжлийн банк энэ хуулийн 5.1-д заасан үнэт цаасанд хууль тогтоомжид нийцүүлэн бие даан баталгаа гаргах бөгөөд уг баталгаанд зориулж төрийн өмчийг барьцаалахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт хамаарахгүй* гэж заасныг үндэслэн МУХБ-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр БА-ЭМГЛ2012-12 дугаартай гэрээг Эрдэнэс Монгол ХХК-тай байгуулж, 550,000,000,000.00 төгрөгийн баталгаа гаргасан байна. Баталгааны хугацаа 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр дуусгавар болсон байна. Гэвч Эрдэнэс Монгол ХХК-ийн хангаагүй үүргийн гүйцэтгэл 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 849,807.0 сая төгрөг байна. Талууд 2025 онд тооцоо нийлээгүй ба эргэн төлөлт хийгдээгүй байна. Засгийн газрын 2025 оны 32 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт *“Эрдэнэс бонд”-ын эргэн төлөлтийг хангах зорилгоор МУХБ ХХК-аас гаргасан “Эрдэнэс бонд”-ын баталгаа 550,000.0 сая төгрөгтэй тэнцэх баталгааг чөлөөлж, Монгол Улсын Засгийн газрын баталгаагаар солих, эсхүл эргэн төлөлтийг хангах бусад шаардлагатай арга хэмжээ авахыг Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайдад даалгаж, Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөсүгэй* гэж заасан ч Засгийн газрын баталгаа гараагүй байна. МУХБ Эрдэнэс бондын үүргийн гүйцэтгэл бүрэн хангагдаагүй байхад баталгааг тэнцлийн гадуурх данснаас шууд хасалт хийж, 2025 оны санхүүгийн тайланг гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг*

хориглоно, 18 дугаар зүйлийн 18.1-д Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ., 20 дугаар зүйлийн 20.2.3-т холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэж заасныг зөрчиж үүргийн гүйцэтгэл хангагдсан анхан шатны баримтлахгүйгээр тэнцлийн гадуур данснаас хассан байна. МУХБ-ны Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмын 2.2.1-д Тэнцлийн гадуур бүртгэлтэй активын үнэ цэнийн бууралтын тооцооллыг хагас жил тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр журмын дагуу тооцож, журмын 2.1-д зааснаар ангиллыг тогтоож, Зээлийн мэдээллийн санд хүргүүлнэ, 2.2.2-т Хөгжлийн банк нь тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүргийг хэрэгжүүлсэн нөхцөлд тэнцлийн дотор холбогдох активын төрөлд үлдэгдэл дүнгээр бүртгэж, журмын 2.1.3, 2.1.5, 3.4.2 болон бусад шаардлагыг мөрдөж ажиллана гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Хөгжлийн банкны 2025 оны санхүүгийн тайлангийн тодруулгад 550,000.0 сая төгрөгийн баталгааг буцаан бүртгэх, эсвэл Засгийн газрын 2025 оны 32 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт заасан нөхцөл биелсэн тохиолдол тэнцлийн гадуурх данснаас хасаж, зөрчлийг арилгах албан шаардлага өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурыг хангаагүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ажлын хэсэг аудитын нээлтийн уулзалтыг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хийж, завсрын аудитаар аудитын урьдчилсан үйл ажиллагаа, байгууллагын гадаад дотоод орчныг судлах, аудитын эрсдэлийг тодорхойлох, аудитын төлөвлөгөө боловсруулах, зарим эрсдэлтэй данстын түвшинд холбогдох горим сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар илэрсэн асуудлыг жилийн дүнгээр нэгтгэн асуудлын бүртгэлээр танилцуулж, шийдвэрлүүлэхээр тогтсон болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Үндэсний аудитын газар Хөгжлийн банкны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийсэн бөгөөд 90.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 950,401.0 сая төгрөгийн 15 албан шаардлага хүргүүлж, 33,271.9 сая төгрөгийн 7 зөвлөмжийг өгснийг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 100.0 хувтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	90,480.0	1	90,480.0	100.0
Албан шаардлага	15	950,400,986.2	15	950,400,986.2	100.0
Зөвлөмж	7	33,271,819.0	7	33,271,819.0	100.0
Нийт дүн	23	983,763,285.2	23	983,763,285.2	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль нь Хөгжлийн бодлого, түүний удирдлагын тухай хуультай бүрэн нийцэхгүй байгаа эрх зүйн зөрчилтэй асуудалд санал боловсруулж УИХ, МУЗГ-т хүргүүлсэн эсэх;

2. МУХБ-ны өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагааны загварыг үндсээр нь өөрчлөхгүй тохиолдолд ашигт ажиллагааг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байгааг анхаарч, бизнесийн загварын шинэчлэл хийх;
3. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ буурсан тул банкны хэвийн үйл ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд дахин мөнгөжүүлэх арга хэмжээ авах;
4. Чанаргүй зээлийн хэмжээг бууруулж, төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх чиглэлээр үр нөлөөтэй арга хэмжээ хэрэгжүүлэх;
5. МУХБ-наас баталгаа гаргасан “Эрдэнэс бонд”-ын үүргийн гүйцэтгэл хангагдахгүй байгаад бодитой үнэлэлт өгч, эрсдэлийг бууруулах шийдвэр гаргах;
6. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд хэт төвлөрөл үүссэнийг бууруулж, засаглал, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
7. Банкны дотоод аудитын газраас мэдээлснээр ТУЗ-ийн гишүүдийн цалинг хууль тогтоомжийн дагуу олгохгүй байгаа асуудлыг тус тус анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа

Аудитаар нийт 1,449,295.4 сая төгрөгийн алдаа¹⁴ илэрснээс аудитын явцад 1,293,344.2 сая төгрөгийн алдааг залруулж, 155,951.2 сая төгрөгийн алдааг залруулах 5 зөвлөмж өглөө.

5.1.1 Залруулсан алдаа:

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Гүйлгээ балансын дебет, кредит гүйлгээний дүн ерөнхий журналын дүнгээс 1,052,744.6 сая төгрөгөөр дутуу, санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлээс 91,220.8 сая төгрөг, эцсийн үлдэгдлээс 145,287.3 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлснийг ;
- Шүүхийн тогтоолоор хүчингүй болсон өмнөх онуудад хуримтлагдсан үндсэн болон нэмэгдүүлсэн хүүгийн авлагыг залруулахдаа тайлант оны хүүгийн орлогыг 4,019.7 сая төгрөгөөр бууруулсныг;
- Хувийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг 1 жилийн хугацаатай авч, Хаан даатгал ХХК-тай 89.3 сая төгрөгийн гэрээг байгуулсан ба 2026 онд хамаарах даатгалын зардлыг 2025 онд зардлаар бүртгэснийг;
- Хамгаалалтын ажил гүйцэтгэх 2/71 дугаартай гэрээний дагуу 2025.05.01-2026.05.01 хугацааны төлбөр болох 31.3 сая төгрөгийг шилжүүлсэн ба 2026 оны 1-4 дүгээр сард хамаарах зардлыг 2025 онд зардлаар бүртгэснийг аудитын явцад тус тус залрууллаа.

Эдгээр нь НББОУС 1.15-д “Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг Үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг”, СТОУС 9-ийн 5.5.8-д “Аж ахуйн нэгж нь тухайн тайлант үеийн эцэс дэх гарзны хасагдуулгыг энэхүү Стандартын дагуу хүлээн зөвшөөрвөл зохих дүнтэй тохируулах шаардлагатай уг хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнг /эсвэл буцаалтыг/ үнэ цэнийн бууралтын олз эсвэл гарз байдлаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө”, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹⁴ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.1.2 Зөвлөмж

Илрүүлэлт 1.

МУЗГ-ын үнэт цаасны бодит үнийн цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн шалгуурт нийцэж байгаа тул ангилал нь СТОУС 9-д нийцэж байгаа ч 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тайланд бодит үнэ цэнээр хэмжиж бүртгээгүй нь СТОУС 9-д нийцэхгүй байна.

МУХБ-ны үнэт цаас буюу өөрийн гаргасан өрийн хэрэглүүрийг худалдаж авсан ажил гүйлгээг СТОУС 9-ийн дагуу санхүүгийн өр төлбөрөөс хасаж бүртгэх ёстой байтал тусад нь хөрөнгөөр бүртгэсэн нь СТОУС 9-тэй нийцэхгүй байна.

Энэ нь СТОУС 9-Санхүүгийн хэрэгсэл стандартын 5.1.1, 5.1.7, СТОУС 13-ын 9, НББОУС 32, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.1.Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт...” гэж заасантай нийцээгүй байна.

МУХБ нь МИК Холдинг ХК-ийн 14.99 хувийг эзэмшдэг бөгөөд тухайн хөрөнгө оруулалтаас МИК Холдинг ХК олон улсын зах зээлд гаргасан бондын төлбөрөө төлж барагдуулж дуусах хүртэл хугацаагаар ногдол ашиг хүртэх боломжгүй байна.

Өгсөн зөвлөмж:

СТОУС 9-Санхүүгийн хэрэгсэл стандартыг мөрдөж хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэх, МУХБ-ны эзэмшиж байгаа МИК Холдинг ХК-ийн хувьцааны үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах.

Илрүүлэлт 2.

МУЗГ-ын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 137 дугаар тогтоол, мөн өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэлээр МУЗГ-ын 2025 оны 32 дугаар тогтоолын 1.1.2-т заасан “ТОСК БОНД”-ын барьцаанд байгаа Ногоон нуур 1008 айлын орон сууцны барилга, байгууламжийг НОСК ХК-д худалдан борлуулж, холбогдох гэрээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээгээр “ТОСК БОНД”-ын төлбөрийг 2025 онд багтаан бүрэн төлж барагдуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар тус тус даалгасугай гэх заалтыг хүчингүй болгож, зорилтот бүлгийн түрээсийн орон сууцны иргэдийг сонгон шалгаруулж, уг орон сууцанд хамруулах асуудлыг зохион байгуулах ажлыг ТОСК ТӨХХК-д чиглэл болгосон байна. Үүнтэй холбоотойгоор ТОСК ТӨХХК-аас ирүүлсэн 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1203 дугаар албан бичгийн хавсралт 1-ийг үндэслэн үнэт цаасны эргэн төлөгдөх эх үүсвэрийн мөнгөн урсгал, үнийн цэнийн бууралтыг тооцоолж үзэхэд 69.48 хувиар буюу 134,343.6 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулахаар тооцсон. Гэвч орон сууцны төслийн борлуулалт ойрын хугацаанд МУЗГ-ын шийдвэрийн хүрээнд нөхөн төлөгдөнө гэж үзэн ТОСК ТӨХХК-ийн бондын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн санг бүртгээгүй байна.

Энэ нь СТОУС 9-Санхүүгийн хэрэгсэл стандартын 5.1.1, 5.1.7, СТОУС 13-ын 9, НББОУС 32 стандарттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТОСК ТӨХХК-ийн өрийн бичгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн санг тооцож, бүртгэх.

Илрүүлэлт 3.

НББОУС 40-ийн дагуу хөрөнгийн зах зээлийн үнэлгээг тодорхойлон, уг үнэлгээг дансны үлдэгдэлтэй харьцуулан эрсдэлийн сан байгуулсан байна. Гэвч өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн эрсдэлийн сан нь дараах хүчин зүйлсээс шууд хамаарч байна. Тухайлбал, Шинэ яармаг төслийн дууссан болон дуусаагүй барилгуудын үнэлгээг 2022 болон 2023 онд тодорхойлсон, Гангиг вилла төслийн үнэлгээг МУХБ-ны ЭУГ-ын хөрөнгийн үнэлгээний сургалтад хамрагдаагүй, гэрчилгээгүй мэргэжилтэн бэлтгэсэн байна. Дуусаагүй

барилгын төслүүдийн борлуулалтын боломж болон тухайн хөрөнгийг борлуулах боломжит хугацааны тооцооллыг, өмчлөх бусад хөрөнгүүдийг 1 жилээс 2.5 жилийн хугацаанд борлуулахаар тооцсон байна. Хэрэв энэ хугацаа нэг жилээр сунгагдвал үнэ цэнийн эрсдэлийн сан 21,407.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 47,565.0 сая болохоор байна.

Энэ нь СТОУС 9-Санхүүгийн хэрэгсэл стандартын 5.1.1, 5.1.7, СТОУС 13-ын 9, НББОУС 32, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д *Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө*, 4.1.1-д *Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт* гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гантиг вилла төслийн үнэлгээг хөрөнгийг борлуулах боломжит хугацааны тооцооллыг үндэслэн 21,407.8 сая төгрөгөөр өсөж, 47,565.0 сая төгрөг болгон эрсдэлийн санг нэмэгдүүлэх.

Илрүүлэлт 4.

Иргэний шүүхээр шийдвэр гарсан 12 зээлийн хувьд барьцаа хөрөнгийн үнэлгээний шүүхийн шийдвэрт тусгасан дүнг эрсдэлийн сангийн тооцоололд ашигласан байна. Өөрөөр хэлбэл, барьцаа хөрөнгийн үнэлгээг зээл олгох үеийн үнэлгээгээр тооцсон нь тухайн барьцаа хөрөнгийг борлуулан ирээдүйд олох орлогын өнөөгийн үнэ цэнийг зөв зохистой тооцсон гэх хангалттай нотолгоо болж чадахгүй байна. Мөн шүүхэд шилжүүлээгүй 7 зээлийн хувьд барьцаа хөрөнгийг мэргэжлийн анхан шатны үнэмлэх аваагүй банкны ажилчид үнэлснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Энэ нь СТОУС 9-Санхүүгийн хэрэгсэл стандартын 5.1.1, 5.1.7, СТОУС 13-ын 9, НББОУС 32, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д *Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө*, 4.1.1-д *Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт* гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Барьцаа хөрөнгийн үнэлгээг эрсдэлийн сангийн тооцоололд ашиглахдаа зах зээлийн нөхцөлд нийцсэн, хараат бус мэргэжлийн үнэлгээнд тулгуурлах, зээлийн барьцаа хөрөнгийн харьцаанд тогтмол хяналт тавьж, барьцаа хүрэлцэхгүй зээлд нэмэлт барьцаа шаардах, эрсдэлийн санг бодитой тогтоох, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах.

Илрүүлэлт 5.

Санхүүгийн тайланд тусгасан биет хөрөнгийн дүн тооллогын бүртгэлээс 181.6 сая төгрөг, биет бус хөрөнгийн дүн 18.0 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т *Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ*, 20.2.6-д *эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах* гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тооллогын үр дүнг эцэслэн шийдвэрлэж, нягтлан бодох бүртгэлд хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв тусгаж байх.

5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил

Аудитаар нийт 1,390,720.0 сая төгрөгийн зөрчил¹⁵ илэрснээс, 37.6 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 1,386,554.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 4,127.7 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

¹⁵ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,546,671.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,544,732.2 сая төгрөгөөр давсан тул Сөрөг дүгнэлт өглөө.

5.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1.

Хөрөнгийн тооллогоор дутагдсан 4.8 сая төгрөгийн үнэ бүхий компьютерын асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр төлүүлнэ гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хөрөнгийн тооллогоор дутагдсан 24041900009 хөрөнгийн кодтой Microsoft surface pro 9 with sim card компьютерын үнийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2.

Урамшуулалт цалин олгох болзол хангаагүй 8 ажилтанд 27.8 сая төгрөгийн цалин, урамшуулалт олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-т *гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах*, 43 дугаар зүйлийн 43.2.1-д *гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх*, МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2023 оны А-34 дүгээр тушаалаар баталсан Ажилтны ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлэх журмын 4.7 дахь хэсэг *Ажилтны хувьд дараах нөхцөлүүд бий болсон бол урамшуулалт цалинд хамрагдахгүй*, 4.7.6 дахь хэсэг *Тайлант хугацааны 75 хувь буюу түүнээс бага хугацаанд ажилласан* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Урамшуулалт цалинд хамрагдах болзол хангаагүй 8 ажилтанд олгосон 27.8 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 3.

Тайлант онд 12 ажилтанд чөлөөтэй, албан томилолттой, өвчтэй байсан хугацаанд хоол, унааны хөнгөлөлт 3.7 сая төгрөг олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-т *Гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах*, 43 дугаар зүйлийн 43.2.1-д *гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх*, 100 дугаар зүйлийн 100.2-т *Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна*, 110 дугаар зүйлийн 110.2-т *Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно*, МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан Цалин хөлсний журмын 6.4 дэх хэсэг *Хоол унааны хөнгөлөлтийг ажилтны ажилласан хоногоор нь тооцож олгох бөгөөд хөнгөлөлтийн хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд Гүйцэтгэх захирал тогтооно*, 7.1 дэх хэсэг *Ажилтны үндсэн цалинг тогтмолоор болон ажилласан цагаар тооцон, ирцийн тайланг үндэслэн олгох бөгөөд*

ажлаас хоцорсон, эрт явсан тохиолдолд тухайн өдрийн ажилласан цагийг үндэслэнэ гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цалинтай чөлөөтэй, албан томилолттой, өвчтэй байсан хугацаанд илүү олгосон цалин, хоол, унааны нэмэгдэл 3.7 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 4.

Гүйцэтгэх захирлын 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Б/116 дугаар тушаалаар ажилтнуудад илүү цагийн цалин, хөлс олгохдоо 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр томилогдсон 1 ажилтанд 1.2 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-т гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах, 43 дугаар зүйлийн 43.2.1-д гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх гэж заасантай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Илүү цагийн цалин хөлс олгохдоо тухайн хугацаанд ажиллаагүй 1 ажилтанд олгосон 1.2 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Илрүүлэлт 5.

МУХБ-ны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Амралтын зөрүү олгох тухай” Б/252 дугаар тушаалаар ээлжийн амралтыг биеэр эдлээгүй ажилтнуудад амраагүй хугацаанд ногдох ээлжийн амралтын цалинг олгохдоо 1 ажилтанд 0.09 сая төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр “Журам батлах тухай” тушаалын хавсралтын 3.4-т Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Илүү олгосон ээлжийн амралтын цалин 0.09 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1.

Мөнгөн хөрөнгө, авлагын үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой дараах зөрчил илэрлээ.

- Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл болох 11,091.9 сая төгрөгийг баталгаажуулаагүй;
- Авлага дансанд бүртгэлтэй 25 зээлийн 1,234,002.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэж заасантай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл, авлагын дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2.

Хөрөнгийн дотоод хяналт, эд хөрөнгийн тооллого, тооллогын үр дүнтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Санхүүгийн тайланд тусгасан 24.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг жилийн эцэст тоолж, баталгаажуулаагүй;
- Өмчлөхөөс бусад хөрөнгө болон борлуулах зориулалттай нийт 141,131.2 сая хөрөнгийн үлдэгдлийг жилийн эцсийн хөрөнгийн тооллогод хамруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1 жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө..., 20 дугаар зүйлийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Бараа материал, өмчлөхөөс бусад хөрөнгө болон борлуулах зориулалттай хөрөнгийн тооллого хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, тооллогыг жилийн эцсийн тайлан гаргахын өмнө заавал хийж байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 3.

МУХБ-ны албан хаагчид болон ТУЗ-ын гишүүд зэрэг 154 хүнд хувийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг авах худалдан авалтыг 2025 онд зохион байгуулж, Хаан даатгал ХХК-тай 89.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т хуулиар зөвшөөрөөгүй бусад, ТУЗ-ийн гишүүдийн хувьд МУЗГ-ын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын 7.7-д ТУЗ-ийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, ажилчдад эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлсэн зөрчлийг таслан зогсоож, албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 4.

- МУХБ-ны Мэдээлэл олон нийттэй харилцах хэлтсийн чиг үүрэгт хамаарах ажлыг гүйцэтгүүлэхээр бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн нэр бүхий 4 ажилтантай ажил гүйцэтгэх гэрээг 2 жилийн хугацаатай байгуулж цалин олгосон, мөн 3 ажилтны гэрээг хугацаанаас өмнө цуцалсан үндэслэлээр 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний торгуулийг тус тус төлж, нийт 165.0 сая төгрөг зарцуулсан.
- МУХБ-ны Эрсдэлтэй активын удирдлагын газрын чиг үүрэгт хамаарах ажлыг гүйцэтгүүлэхээр бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн 1, нэр бүхий 3 иргэнтэй сарын

3.5-4.5 сая төгрөгийн хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, нийт 46.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т *Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх* заасан хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчимд нийцээгүй, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д *...төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоохыг хориглоно* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, байгууллагын үндсэн чиг үүрэг, орон тоонд хамаарах ажлыг давхардуулан гэрээгээр гүйцэтгүүлэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 5.

Монголын тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн холбооноос зохион байгуулсан Тогтвортой санхүү, бизнесийн өндөр түвшний туршлага судлах Австрали, Шинэ Зеланд улсад хийсэн аяллын хүрээнд МУХБ-ны 2 ажилтан хамрагдсан бөгөөд аяллын нэгдсэн төсөвт магадалшгүй зардал болон хот доторх унааны зардал төсөвлөн тус байгууллагад мөнгийг шилжүүлсэн байхад МУХБ-ны томилолтын төсөвт магадалшгүй зардалд 1000.0 ам.доллар, хот доторх тээврийн зардалд 240.0 ам.доллар, нийт 1,240.0 ам.доллар буюу 4.5 сая төгрөгийг төлөвлөж, зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т *хуулиар зөвшөөрөөгүй бусад* болон МУХБ-ны "Албан томилолтын журам"-ын 4.7-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан томилолтын зардалд магадалшгүй ажлын зардал болон хот доторх тээврийн зардлыг давхардуулан төсөвлөж, зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1.

Нийт 3,190.7 сая төгрөгийн 1,619 ширхэг элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй, мөн анхны өртгөө нөхсөн 323.1 сая төгрөгийн 196 ширхэг үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасах шийдвэр гараагүй байхад балансын гадуур бүртгэсэн байна. Өмч хамгаалах зөвлөлд тооллогын комиссоос ашиглах боломжгүй 273.7 сая төгрөгийн 198 ширхэг хөрөнгийг актлах саналыг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.

Энэ нь МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/121 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 2.3 "Үндсэн хөрөнгийн бүртгэлийн заавар"-т үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасахад ТУЗ-ийн тогтоол, гүйцэтгэх захирлын тушаал, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэнэ гэж заасныг мөрдөж ажиллагүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө данс бүртгэлээс хасахдаа ТУЗ-ийн тогтоол, гүйцэтгэх захирлын тушаал, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэх зөвлөмж өглөө.

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 2.

Ажлын зайлшгүй шаардлагын улмаас 131 ажилтныг илүү цагаар ажиллуулсан хэрэгцээ шаардлага бүрэн нотлогдоогүй, ажлын үр дүнг үнэлж дүгнээгүй, эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр 2025 оны 12 дугаар сард нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-т *гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах*, 43 дугаар зүйлийн 43.2.1-д *гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх*, МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Цалин хөлсний журам"-ын 5.1.1 дэх хэсэг *үүрэг даалгаврыг богино хугацаанд гүйцэтгэх ажлын зайлшгүй шаардлагын улмаас илүү цагаар ажилласан, илүү цагаар ажиллахыг удирдлагаас даалгасан тохиолдолд ажилтны ажилласан цагийн бүртгэл, гүйцэтгэсэн ажлыг үнэлсэн удирдлагын үнэлгээ, Хүний нөөцийн асуудал хариуцсан газрын захирлын зөвшөөрлөөр* гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ажилтныг илүү цагаар ажиллуулахдаа ажилласан цагийн бүртгэл, гүйцэтгэсэн ажлыг үнэлсэн удирдлагын үнэлгээ, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл, тушаал, шийдвэрт үндэслэн олгох зөвлөмжийг хүргүүллээ.

3. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 3.

"Цалинтай дадлагажигчийн хөтөлбөр" хэрэгжүүлж 2025 онд 5 оюутантай гэрээ байгуулж, цалин, хоол, унаа зэрэгт нийт 6.3 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т *хуулиар зөвшөөрөөгүй бусад*, 15 дугаар зүйлийн 15.1.2-т *чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, тэвчиж болох зардлыг хэмнэж ажиллах зөвлөмж өглөө.

4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт 4.

МУХБ-наас Грэйпсити Монгол ХХК-тай программ хангамжийн засвар үйлчилгээний 330.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулсан байна. Энэхүү гэрээг байгуулахдаа санхүүжилтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, ТБНӨБАҮХАТХ-ийн дагуу тендер зарлаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д *Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна*", 44 дүгээр зүйлийн 44.1-д *Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална* дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.8-д *энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах* гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТБОНӨХБАҮХАТХ-ийн хэрэгжилтийг хангаж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээг бүрэн тусгаж ажиллах зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гүйлгээ балансын дебит, кредит гүйлгээний дүн ерөнхий журналын дүнгээс 1,052,744.6 сая төгрөгөөр дутуу, санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлээс 91,220.8 сая төгрөг, эцсийн үлдэгдлээс 145,287.3 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн.	1	1,289,252,696.6					1	1,289,252,696.6				
Шүүхийн тогтоолоор хүчингүй болсон өмнөх онуудад хуримтлагдсан үндсэн болон нэмэгдүүлсэн хүүгийн авлагыг залруулахдаа тайлант оны хүүгийн орлогыг 4,019.7 сая төгрөгөөр бууруулсан.	1	4,019,689.7					1	4,019,689.7				
ЗГҮЦ-ыг анх худалдан авсан үеийн бодит үнэ цэнээр хэмжсэн боловч дараа үеийн хэмжилт хийгээгүй. Банк өөрийн гаргасан өрийн хэрэглүүрийг худалдаж авсан ажил гүйлгээг СТОУС 9-н дагуу санхүүгийн өр төлбөрөөс хасаж бүртгэх ёстой байтал тусдаа хөрөнгөөр бүртгэсэн. Банк эдгээр үнэт цаасыг гаргагч/оролцогч талуудын зээлжих зэрэглэл 2024-2025 онд мэдэгдэхүйц буураагүй тул материаллаг үнэ цэнийн бууралтын сан байгуулаагүй байна.	1	-									1	-
ТОСК бондын эргэн төлөгдөх эх үүсвэрийн мөнгөн урсгал, үнийн цэнийн бууралтыг үнэлэн 69.48 хувиар буюу 134,343.6 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулахаар тооцсон ч эрсдлийн санг байгуулаагүй	1	134,343,595.1									1	134,343,595.1

Монгол Улсын Хөгжлийн банкний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Шинэ яармаг төслийн дууссан болон дуусаагүй барилгуудын үнэлгээг 2022 болон 2023 онд тодорхойлсон, Гантиг вилла төслийн үнэлгээг МУХБ-ны ЭУГ-ын хөрөнгийн үнэлгээний сургалтад хамрагдаж гэрчилгээ аваагүй мэргэжилтэн бэлтгэсэн байна.	1	21,407,840.9									1	21,407,840.9
Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарсан 12 зээлийн хувьд шүүхийн шийдвэрт тусгасан барьцаа хөрөнгийн үнэлгээний дүнг эрсдэлийн сангийн тооцоололд ашигласан байна.	1	-									1	-
Санхүүгийн тайланд тусгасан биет хөрөнгийн дүн тооллогын бүртгэлээс 154.5 сая төгрөгөөр, биет бус хөрөнгийн дүн 88.6 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн.	1	199,753.9									1	199,753.9
МУХБ нь хувийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг 1 жилийн хугацаатай авч, Хаан даатгал ХХК-тай 89.3 сая төгрөгийн гэрээг байгуулсан ба 2026 онд хамаарах даатгалын зардлыг 2025 онд зардлаар бүртгэсэн байна.	1	61,422.8					1	61,422.8				
МУХБ-аас Хамгаалалтын ажил гүйцэтгэх 2/71 дугаартай гэрээний дагуу 2025.05.01-2026.05.01 хугацааны төлбөр болох 31.3 сая төгрөгийг шилжүүлсэн ба 2026 оны 1-4 дүгээр сард хамаарах зардлыг 2025 онд зардлаар бүртгэсэн байна.	1	10,429.0					1	10,429.0				
Дүн	9	1,449,295,428.1	-	-	-	-	4	1,293,344,238.1			5	155,951,190.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	11,091,885.1				11,091,885.1							
Тайлант онд 33 зээлийн үндсэн болон хүү, алдангийн төлбөрийн 2,331,849.3 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 25 зээлийн 1,234,002.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	1,234,002,631.5			1	1,234,002,631.5							
Санхүүгийн тайланд тусгасан 24.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг жилийн эцэст тоолж, баталгаажуулаагүй байна.	1	24,115.4				24,115.4							
Өмчлөхөөс бусад хөрөнгө болон борлуулах зориулалттай нийт 141,131.1 сая хөрөнгийн үлдэгдлийг жилийн эцсийн хөрөнгийн тооллогод хамруулаагүй байна.	1	141,131,148.4			1	141,131,148.4							
Нийт 3,190.7 сая төгрөгийн 1,619 ширхэг элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй, мөн анхны өртгөө нөхсөн 323.1 сая төгрөгийн 196 ширхэг үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасах шийдвэр гараагүй байхад балансын гадуур бүртгэсэн. Өмч хамгаалах зөвлөлд тооллогын комиссоос ашиглах боломжгүй 273.6 сая төгрөгийн 198 ширхэг хөрөнгийг актлах саналыг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.	1	3,787,557.1					1	3,787,557.1					

Хөрөнгийн тооллогоор дутагдсан 4.7 сая төгрөгийн үнэ бүхий компьютерын асуудлыг шийдвэрлээгүй байна.	1	4,772.2	1	4,772.2								
Ажитнуудад урамшуулал олгохдоо урамшуулалт цалин хамрагдах болзол хангаагүй 8 ажилтанд 27.8 сая төгрөгийг олгосон.	1	27,850.0	1	27,850.0								
1.Тайлант онд 12 ажилтны цалинтай чөлөөтэй, албан томилолттой, өвчтэй байсан хугацаанд хоол, унааны хөнгөлөлт 3.7 сая төгрөг олгосон.	1	3,667.5	1	3,667.5								
Ээлжийн амралтыг биеэр эдлээгүй ажилтнуудад амраагүй хугацаанд ногдох ээлжийн амралтын цалинг олгохдоо 1 ажилтанд 0.09 сая төгрөгийг илүү олгосон.	1	91.3	1	91.3								
Ажилтнуудад илүү цагийн цалин, хөлс олгохдоо 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр томилогдсон 1 ажилтанд 1.3 сая төгрөг олгосон.	1	1,262.7	1	1,262.7								
2025 оны 12 дугаар сард 131 ажилтны ажлын зайлшгүй шаардлагын улмаас илүү цагаар ажилласан нь нотлогдоогүй, эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэргүй байхад 259.9 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон.	1	-					1	-				
МУХБ-аас Грэйпсити Монгол ХХК-тай мэдээлэл технологийн үйлчилгээ авах 330.8 сая төгрөгийн гэрээ байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу тендер зарлаагүй, МУХБ-ны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна.	1	330,873.2					1	330,873.2				
МУХБ-ны албан хаагчид болон ТУЗ-ын гишүүд зэрэг 154 хүнд хувийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг авах худалдан авалтыг 2025 онд зохион байгуулж, Хаан даатгал ХХК-тай 89.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.	1	89,320.0			1	89,320.0						

МУХБ-ны МОНХХ-ийн чиг үүрэгт хамаарах ажлыг гүйцэтгүүлэхээр бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн нэр бүхий 4 ажилтантай ажил гүйцэтгэх гэрээг 2 жилийн хугацаатай байгуулж, цалин хөлс олгосон, мөн 3 ажилтаны гэрээг хугацаанаас өмнө цуцалсан үндэслэлээр 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний торгуулийг тус тус төлсөн байна.	1	165,036.9			1	165,036.9						
МУХБ-ны ЭАУГ-ын чиг үүрэгт хамаарах ажлыг гүйцэтгүүлэхээр бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн нэр бүхий 4 ажилтанд сард 3.5-4.5 сая төгрөгийн хөлс олгохоор гэрээ байгуулж 46.1 сая төгрөг олгосон.	1	46,103.0				46,103.0						
Австрали, Шинэ Зеланд улсад хийсэн аяллын хүрээнд МУХБ-ны 2 ажилтан хамрагдсан бөгөөд аялалын нэгдсэн төсөвт магадлашгүй зардал болон хот доторх унааны зардал төсөвлөн тус байгууллагад мөнгийг шилжүүлсэн байхад МУХБ-ны томлолтын төсөвт магадалшгүй зардалд 1000\$, хот доторх тээврийн зардалд 240\$, нийт 1,240 ам.доллар буюу 4.4 сая төгрөгийг төлөвлөж, зарцуулсан байна.	1	4,455.9			1	4,455.9						
Нийт 5 оюутантай цалинтай дадлагажигчийн гэрээг байгуулж цалин, хоол, унааны 6.3 сая төгрөг олгосон.	1	6,250.0					1	6,250.0				
Дүн	17	1,390,717,020.2	5	37,643.7	5	1,386,554,696.2	5	4,124,680.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил						
МУХБ-ны үйл ажиллагаа, санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагатай нийт 34.8 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	34,810.0	1	34,810.0		
МУХБ-аас 2024 оны үйл ажиллагааны тайланг монгол, англи хэлээр 170 ширхэг, хураангуй буюу гарын авлагыг монгол, англи хэлээр 290 ширхэг хэвлүүлсэн бөгөөд их хэмжээгээр хэвлэж, тараах, зайлшгүй хэрэгцээ шаардлага тогтоогдоогүй, түүнчлэн бүртгэлд бүртгэн хүлээн авсан, зарлагадсан санхүүгийн баримт байхгүй байна.	1	11,070.0	1	11,070.0		
МУХБ-ны Маркетинг, олон нийттэй харилцах хэлтэст хамааралтай ажил болох цахим хуудас болон брэндбүүкийг байгууллагын ажилтнууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад танилцуулж, сурталчлах, контент бэлтгэх ажлыг гүйцэтгүүлэхээр Түшиг арвин үйлс ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Мөн тайлант онд хэвлэл захиалын төлбөрт 1.1 сая төгрөг шилжүүлсэн.	1	3,303.0	1	3,303.0		
"Банкир 2025", ЭЗХС-ийн нэрэмжит тэмцээн зэрэг спортын тэмцээн, уралдааныг зохион байгуулахад 30.1 сая төгрөг, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Хүүхэд хамгааллын өдөр"-т сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулахад 20.9 сая төгрөг, "Зочин төлөөлөгчийн зардал" нэрээр кофе, ус ундаа, чихэр, жимс зэргийг худалдан авахад 45.0 сая төгрөгийг зарцуулсан.	1	75,191.8	1	75,191.8		
Байгууллагын цахим хуудаст ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлын ажлын байранд тавигдах шаардлага, гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, компанийн 2025 онд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, ЭМДШ, НДШ-ийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна.	1	-			1	-
Дүн	5	124,374.8	4	124,374.8	1	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах нийт 64 тушаал шийдвэрээс 1,439.9 сая төгрөгийн 53 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний нийт 114 гүйлгээнээс 84.2 сая төгрөгийн 4 мэдээллийг мэдээлээгүй, 4,454.1 сая төгрөгийн 80 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр,	1	9,054,617.0	1	9,054,617.0		

хаяг ил тодоор мэдээлэх нийт 73 мэдээллээс 2,804.2 сая төгрөгийн 62 мэдээллийг нийтэд ил тод мэдээлээгүй байна.						
Дүн	1	9,054,617.0	1	9,054,617.0	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд зааснаар МУХБ-ны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн байх ёстой хэдий ч Алсын хараа 2050, Таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах, төсөлд санал авах, батлуулах, хэрэгжүүлэх үе шатанд МУХБ хэрхэн оролцож хамтран ажиллах талаар эрх зүйн ямар нэгэн зохицуулалтгүй, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 23.2 -д УИХ, Засгийн газар МУХБ-ны санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй, харин Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байх, 20.2-т эх үүсвэрүүдийг дурдаж өгсөн ч Хөгжлийн банкны эх үүсвэрийг ашиглах эсэх нь тодорхой тусгагдаагүй зэргээс харахад "үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх" хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Хөгжлийн банк санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрөө хэрхэн яаж сонгох нь тодорхойгүй, өмнөх хугацаанд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь Засгийн газрын тогтоол, шийдвэрээр, МУЗГ-аас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийг дэмжсэн төслүүд байгаа ч төрийн бодлогыг хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэрийнхээ үр дагаварыг хариуцаагүйгээс чанаргүй ангилалд бүртгэгдэж, өр төлбөр нь хугацаандаа төлөгдөөгүйгээс Хөгжлийн банкны удирдлагаас нэмж төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх шийдвэр гаргах боломжгүй болсноор эх үүсвэр байгаа ч ашиглалтгүй, эсрэгээрээ Монгол Улсын хөгжлийг ахиулах томоохон төсөл, хөтөлбөрүүд санхүүжилтийн эх үүсвэргүй байна. МУХБ богино хугацаатай арилжааны нөхцөлтэй эх үүсвэрээр урт хугацаанд хэрэгжих төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх өнөөгийн загвараар 15 жилийн турш үйл ажиллагаагаа явуулж байгаа нь үр дүнд хүрээгүй байна. МУХБ 2025 онд хууль эрх зүйн орчныг шинэчлэхээр хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт өргөн барьсан боловч эцэслэн батлагдаагүй байна.	1	-			1	-
Банкны өөрийн хөрөнгө багасаж байгаатай холбоотойгоор гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргалт хумигдаж, банкны ТУЗ-ийн хурлаар ихэнх шийдвэр гарч байгаа нь шийдвэр гаргалт нэг талд төвлөрч, банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ТУЗ-ийн оролцоо нэмэгдэж, гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг багассан байна. Энэ нь олон шат дамжлагаар шийдвэр гаргалт удаашрах нөхцөл бүрдүүлсэн байна.	1	-			1	-
Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсын Хөгжлийн банк ТӨХК-ийн засаглалыг "хангалтгүй" үнэлсэн байна. Шалтгаан нь МУХБ нь ТУЗ-ийн залгамж халааны бодлогыг боловсруулж, үйл ажиллагааны тайланд ТУЗ-	1	-	1		-	

<p>ийн гишүүдийн мэдээллийг дэлгэрэнгүй тусгаж, ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй, ТУЗ нь дэргэдэх хороодоор дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эцсийн хариуцлагыг хүлээдэг боловч аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо, эрсдэлийн хороодын үйл ажиллагааны журмыг тусгайлан батлаагүй, нээлттэй мэдээллийг байнга ил тод байлгах үүргээ хэрэгжүүлээгүй, олон нийтэд ил тод мэдээлж буй байгууллагын үйл ажиллагааны тайланд хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэх зэрэг мэдээллийг иж бүрнээр нь тусгаагүй, ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг батлаагүй, мөн тус банкны дүрэмд ТУЗ-ийн гишүүдийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнд суурилсан шалгуурыг бүрэн тусгаагүй, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь Гүйцэтгэх захиралтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээ, түүний үр дүнг жил бүр дүгнэж ТУЗ-д танилцуулах чиг үүрэгтэй ч Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч он дуусахаас өмнө чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор хөдөлмөрийн гэрээний үр дүнг үнэлж, дүгнээгүй, МУХБ-ны гүйцэтгэх удирдлага, тэргүүн дэд захирал, газрын захирлуудыг хуульд заасны дагуу сонгон шалгаруулах журмыг батлаагүй зэрэгтэй холбоотой байна. Энэ зөрчил нь өмнөх хугацаанд ч оршин байсан бөгөөд одоо ч хэвээр байна.</p>					
<p>МУХБ-ны гүйцэтгэх удирдлага, нэгжийн удирдлагуудыг нээлттэй сонгон шалгаруулалт явуулахгүйгээр үүрэг гүйцэтгэгчээр шууд томилж байгаа нь хуулийн өмнө хүн бүр тэгш боломжоор хангагдах зарчмыг алдагдуулж, байгууллагын удирдлагын тогтворгүй байдлаас томилогдсон удирдлага бүр байгууллагын үйл ажиллагаа, ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийлгүйгээр бүтцийн өөрчлөлт хийж байгаагаас чиг үүргийн давхардал, хийдэл ажиглагдаж, ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах байдал хангалтгүй байна. Тухайлбал, МУХБ нь 2023-2025 онд 6 ажилтныг ажлаас үндэслэлгүйгээр халсан нь шүүхээр тогтоогдож, 2023 онд 1 ажилтанд 172.3 сая, 2024 онд 4 ажилтанд 270.4 сая, 2025 онд 1 ажилтанд 36.1 сая, нийт 478.9 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 2025 онд 12 ажилтанд 155.8 сая төгрөгийн нөхөн олговор олгож, үргүй зардал гаргасан байна.</p>	1	191,934.7		1	191,934.7
<p>МУХБ нь 2025 оны бизнес төлөвлөгөөндөө зээлийн багцыг 50 хувиар нэмэгдүүлж, 2,000,000.0 сая төгрөгийн шинэ зээл олгохоор төлөвлөсөн боловч тайлант хугацаанд шинээр зээл огт олгоогүй байна. Мөн олон улсын зах зээлээс 800.0 сая ам.долларын эх үүсвэр татахаар төлөвлөснөөс 500.0 сая ам.долларын эх үүсвэр татсан нь төлөвлөгөөний хэрэгжилт 62.5 хувьтай биелсэн, төлөвлөлтийн үндэслэл бодит нөхцөл байдалтай нийцээгүй, хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.Мөн банкны үйл ажиллагааг дунд хугацаанд чиглүүлэх тодорхой стратеги бүрэн тодорхойлогдоогүй, жилийн бизнес төлөвлөгөөний уялдаа хангалтгүй байгаа нь зээлийн үйл</p>	1	-		1	-

ажиллагааг төлөвлөсөн түвшинд хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан байна. Ийнхүү банкны үндсэн үйл ажиллагаа болох зээл олголтыг хэрэгжүүлээгүй нь төлөвлөлтийн бодит байдал, хэрэгжилтэд тавих удирдлага, зохион байгуулалт, хяналтын үр нөлөөтэй тогтолцоо байхгүйг илтгэж байна.					
Тайлант онд 33 зээл бүртгэлтэй байгаагаас 25 зээл чанаргүй ангилалд шилжсэн нь зээлийн багцын чанар эрс муудсаныг харуулж байна. Үүний улмаас МУХБ-ны хүүгийн орлого буурч, зардлын дарамт нэмэгдэн хүүгийн орлого, зарлагын хооронд ихээхэн зөрүү үүсэж, банкны алдагдал цаашид нэмэгдэх нөхцөл бүрдсэн байна. Энэ нь зээлийн эрсдэлийн удирдлага, зээл олголт болон хяналтын тогтолцоо хангалтгүй байсныг харуулж байгаа бөгөөд банкны санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэл үүссэн байна. Зээлийн багцын чанарыг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, зээлийн эрсдэлийн удирдлага болон хяналтын механизмыг бодитойгоор бэхжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.	1	-		1	-
Тайлант онд МУХБ 500.0 сая ам.долларын үнэт цаасыг гадаад зах зээлд 8.5 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатайгаар 2025.07.03-ны өдөр гаргасан байна. Татан төвлөрүүлсэн эх үүсвэрээс DBM 2026 бондын 122.3 сая ам.долларыг хугацаанаас нь өмнө 11.0 хувийн хүүгийн өгөөжтэй дахин санхүүжүүлсэн байна. Эх үүсвэрийн үлдэгдэл 377.7 сая ам.долларыг банк зээл гаргаагүй тул хадгаламжид эх үүсвэрийн хүүгээс бага хүүтэй буюу 3.5-6.0 хүүтэй байршуулж байна.	1	-		1	-
Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т Монгол Улсын Хөгжлийн банк энэ хуулийн 5.1-д заасан үнэт цаасанд хууль тогтоомжид нийцүүлэн бие даан баталгаа гаргах бөгөөд уг баталгаанд зориулж төрийн өмчийг барьцаалахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт хамаарахгүй гэж заасныг үндэслэн МУХБ-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр БА-ЭМГЛ2012-12 дугаартай гэрээг Эрдэнэс Монгол ХХК-тай байгуулж, 550,000.0 сая төгрөгийн баталгаа гаргасан байна. Баталгааны хугацаа 5 жил бөгөөд 2025.02.20-ны өдөр дуусгавар болсон байна. Гэвч Эрдэнэс Монгол ХХК-ийн хангаагүй үүргийн гүйцэтгэл 2024.12.31-ний өдрийн байдлаар 849,807.0 сая төгрөг байна. Талууд 2025 онд тооцоо нийлээгүй ба төлөлт хийгдээгүй байна. Засгийн газрын 2025 оны 32 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт “Эрдэнэс бонд”-ын эргэн төлөлтийг хангах зорилгоор “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-аас гаргасан “Эрдэнэс бонд”-ын баталгаа 550,000.0 сая төгрөгтэй тэнцэх баталгааг чөлөөлж, Монгол Улсын Засгийн газрын баталгаагаар солих, эсхүл эргэн төлөлтийг хангах бусад шаардлагатай арга хэмжээ авахыг ЭЗХС, Сангийн сайдад даалгаж, Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөсүгэй” гэж заасан ч Засгийн газар баталгаа гараагүй байна. Үүргийн гүйцэтгэл хангагдаагүй байхад МУХБ баталгааг тэнцлийн гадуурх данснаас шууд хасалт хийсэн байна.	1	550,000,000.0	1	550,000,000.0	
Тайлант хугацаанд Монголбанк болон Засгийн газраас хийсэн ээлжит хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, өгсөн зөвлөмжийг	1	-		1	-

хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг ДАГ-аас Монголбанкны хувьд 71.4 хувь, Засгийн газрын шалгалтын хэрэгжилт 16.7 хувь байгаа гэж үнэлсэн нь зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. Мөн Дотоод аудитын газраас 2025 онд 9 сэдвийн хүрээнд аудит хийж зөвлөмж хүргүүлсэн боловч зөвлөмжийн хэрэгжилт 56.0 хувьтай байгаа нь дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах удирдлагын хяналт хангалтгүй байгааг харуулж байна.						
МУХБ-аас охин компаниудад тавих хяналт хангалтгүй. Тухайлбал, 2025 оны 02 дугаар сараас хойш Ди Би Эм ассет менежмент ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнгүй үйл ажиллагаа явуулж, ТУЗ-ийн 18 тогтоол хараат бус гишүүний оролцоогүйгээр батлагдсан, МУЗГ-аас АХБ-тай байгуулсан буцалтгүй тусламжийн гэрээний хүрээнд хэрэгжсэн Ди Би Эм ассет менежмент ХХК-ийн Касталиа лимитед ХХК-тай байгуулсан гэрээнд заасан хяналтыг МУХБ-аас хэрэгжүүлээгүй, төсөл хугацаандаа үр дүнтэй хэрэгжээгүй, түүнчлэн Ди Би Эм ассет менежмент ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Тэмүүжинг Монгол Улсын Хөгжлийн банкны Хөрөнгийн удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгчийн ажлыг давхар гүйцэтгүүлж, мөн МУХБ-тай Олон улсын зах зээлд үнэт цаас гаргах үйл ажиллагааны хүрээнд хаалттай бонд гаргах тохиромжит бүтцийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид банкны investor deck-ийг танилцуулах, хөрөнгө оруулагчийн магадлан шинжилгээний асуудалд хариулах, хөрөнгө оруулагчтай хэлэлцээрт орох, бусад санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх боломжийг судлах, эх үүсвэрийг эрэлхийлэн холбогдох зөвлөгөөг өгөх хөлсөөр ажиллах гэрээг 2025.03.14-ний өдрөөс 2 сарын хугацаатай байгуулж, 2025.05.14-ний өдөр гэрээг 2 сараар сунган ажиллуулж, нийт 2024-2025 онд 88.3 сая төгрөгийн цалин, хөлс олгосон байна.	1	88,335.6	1	88,335.6		
Дүн	10	550,280,270.3	2	550,088,335.6	7	191,934.7

